

“САНХҮҮГИЙН ЗОРИЛТОТ ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ” НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ ГАРГУУЛАХ ХҮСЭЛТИЙН МАЯГТ

“Терроризмтой тэмцэх тухай хууль”-ийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аливаа хүн, хуулийн этгээд, тэрчлэн гадаад улсад үйл ажиллагаа явуулж буй Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн зүгээс хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдэд санхүүгийн гүйлгээ, санхүүгийн үйлчилгээ үзүүлэх болон хөрөнгө ашиглах аливаа үйлдэл хийхийг хуулиар хориглосон.

Тус хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т “Энэ хуулийн 7.1.7-д заасан жагсаалтад орсон этгээд, эсхүл түүний удирдлагад хамаарах этгээд, түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлөөс зөвшөөрөгдөөгүй этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад үйлчилгээ үзүүлэхийг хориглоно” гэж заасан.

Хэрэв хуулийн этгээд хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эсхүл шууд болон шууд бус хяналтад байгаа хөрөнгө гэдгийг олж мэдсэн тохиолдолд хөрөнгийг нэн даруй царцааж, энэ талаар эрх бүхий байгууллагад 48 цагийн дотор мэдэгдэх ёстой бөгөөд энэ үүргийг Терроризмтой тэмцэх тухай хуулиар хуульчилж өгсөн болно. Тухайлбал, тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7-д хуулийн этгээд нь “Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөл, гадаад улсын эрх бүхий байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу болон Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад орсон террорист үйлдэл, террорист хүн, террорист байгууллага, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээд болон тэдгээртэй хамаарал бүхий хувь хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогыг нэн даруй зогсоож холбогдох эрх бүхий байгууллагад 48 цагийн дотор мэдэгдэх үүрэгтэй” гэж заасан.

“Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 4.1-т заасан мэдээлэх үүрэгтэй этгээд нь тус хуулийн 6¹.2-т “энэ хуулийн 4.1-д заасан этгээд нь хориг арга хэмжээний жагсаалтад хамаарах хүн, хуулийн этгээд, аливаа бүлэг, нэгдлийн нэр илэрсэн, мэдсэн даруйд урьдчилан мэдэгдэлгүйгээр холбогдох данс, хөрөнгийн хөдөлгөөнийг шууд зогсоож, холбогдох эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр гүйлгээ хийх эрхгүй болгож, энэ тухай Санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдээлнэ” гэж заасны дагуу хөрөнгийг нэн даруй царцааж “Террорист этгээдийн жагсаалтад оруулах, жагсаалтад орсон этгээдийн хөрөнгийн хөдөлгөөнийг хянах, зогсоох журам”-ын дагуу холбогдох байгууллагад мэдэгдэнэ.

Дээр дурдсан хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу хуулийн этгээдийн зүгээс тухайн хөрөнгө нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй холбоотой эсэхийг баталгаажуулах зорилгоор нэмэлт мэдээлэл авахад энэхүү маягтыг бөглөх шаардлагатай.

Хөрөнгийг баталгаажуулах хугацаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж тухайн хөрөнгийг урьдчилан заавал царцаасан байх ёстой.

Маягтыг нэг бүрчлэн бөглөж дараах хаягаар илгээнэ. Үүнд:

- Санхүүгийн мэдээллийн алба - fiu@mongolbank.mn
- Тагнуулын ерөнхий газар - amltf@gia.gov.mn

Хэрэв та энэхүү эзэмшиж буй хөрөнгө дээрх үүрэг хариуцлагын талаар эргэлзэж байгаа бол баталгаажуулах аргыг хайж олохын тулд энэ маягтыг ашиглаж болно.

Санхүүгийн хориг арга хэмжээ авах үүрэг хүлээсэн сэжиг бүхий этгээдүүд шалгалт хийхдээ царцаах ёстой.

Дууссан маягтуудыг дараах холбоо барих цэгүүдэд илгээнэ үү

- Санхүүгийн мэдээллийн алба (мэдээлэх үүрэгтэй этгээдүүд)
- Тагнуулын ерөнхий газар (бусад)

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ ГАРГУУЛАХ ХҮСЭЛТ ТАВЬСАН ЭТГЭЭДИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

Хүсэлт гаргасан хүн, хуулийн этгээдийн нэр:

.....
Шуудангийн хаяг:.....
Хаяг байршил:.....
Холбоо барих хүн, хуулийн этгээд:.....
Утасны дугаар:.....
Э-шуудан:.....

ТУХАЙН ЭТГЭЭДИЙН ТАЛААР АВАГДСАН НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

Эх сурвалж:

Банкны харилцагч **Төлбөр тооцооны сан**
Банкны бус харилцагч **Мэдээллийн сан**

Харилцагч/үйлчлүүлэгчийн овог нэр:.....
Харилцагч/үйлчлүүлэгчийн хаягийн мэдээлэл:.....
Харилцагч/үйлчлүүлэгчийн төрсөн он, сар, өдөр:.....
Дансны мэдээлэл:.....
Тухайн этгээдтэй холбоотой хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээлэл:
.....
.....
Тухайн этгээдтэй холбоотой бичиг баримт, түүний дэлгэрэнгүй мэдээлэл:
.....
.....
Бичиг баримтын хуулбарыг хавсаргасан эсэх: Тийм Үгүй

Хориг арга хэмжээний жагсаалтад орсон эсэх лавлагаа:

Монгол Улсын эрх бүхий байгууллагаас гаргасан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн дугаар:
НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалтын дугаар:
.....
Жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн нэр:
.....
.....

ГҮЙЛГЭЭНИЙ УТГА, МЭДЭЭЛЭЛ (ХЭРЭВ БОЛОМЖТОЙ БОЛ)

Илгээгчийн нэр:
.....
Илгээгчийн шуудангийн хаяг:
.....
Илгээгчийн хаяг:
.....
Илгээгчийн бусад дэлгэрэнгүй мэдээлэл:
.....
Хөрөнгийн эх үүсвэр:
.....

Хүлээн авагчийн нэр:

Хүлээн авагчийн шуудангийн хаяг:

Хүлээн авагчийн хаяг:

Хүлээн авагчийн бусад дэлгэрэнгүй мэдээлэл (банкны дансдын мэдээлэл зэрэг):

Гүйлгээний огноо, байршил:

Гүйлгээний утга, шилжүүлгийн зорилго:

Сэжигтэй гүйлгээний мэдээлэл явуулсан эсэх: Тийм Үгүй

Тийм бол, СГМ явуулсан огноо:

СГМ-ийн дугаар:.....

БУСАД НЭМЭЛТ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ, САНАЛ ХҮСЭЛТ

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНААС ОРУУЛАХ ХЭСЭГ

Мэлээлэл хүлээн авсан огноо:

.....

Мэдээлэл хүлээн авсан хэлбэр:

Факс: Утас: Имэйл:

СМА-тай холбоо барих мэдээлэл:

Холбоо барих албан тушаалтан:

Утасны дугаар:

Факсны дугаар:

Э-шуудан хаяг:

СМА-ны дүн шинжилгээ:

Хариу өгсөн огноо:

Хариу илгээсэн э-шуудан:

Дүгнэлт өгсөн байдал:

Хөрөнгө нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эсхүл хяналтад байдаг байх магадлалтай.

Хөрөнгө нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эсхүл хяналтад байдаггүй

Хөрөнгө нь хориг арга хэмжээний жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн өмчлөл, эсхүл хяналтад байдаг эсэх нь тодорхойгүй

Өөр нэмэлт мэдээлэл бий эсэх:
